



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/790

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар” Ховд аймгийн ногоон хөгжлийн /2016-2026/ хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.6 дахь заалтын нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжиж чадавхжуулах, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас “Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүд”-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулагдаж буй “Экологид ээлтэй бүтээгдэхүүн-2019” чуулган үзэсгэлэнд оролцоход шаардагдах зардал болон үйл ажиллагаагаараа тэргүүлсэн нөхөрлөлийн урамшуулалд 2 024 400 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 2 024 400 төгрөг /хоёр сая хорин дөрвөн мянга дөрвөн зуун/-ийг “Цайны зам өв соёлын II наадам”-ын санхүүжилтын хэмнэлтээс санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д тус тус зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/790 Ч
02 03848

Аймгийн Засаг даргын 2019 оны
11 дүгээр сарын 28-ны өдрийн
А/790 дүгээр захирамжийн хавсралт



“ЭКОЛОГИД ЭЭЛТЭЙ БҮТЭЭГДЭХҮҮН-2019” БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТИЙН НӨХӨРЛӨЛҮҮДИЙН
ЧУУЛГАН, ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ БЭЛТГЭЛ
АЖЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

д/д	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ/төгрөг/
1	Үзэсгэлэнгийн талбай Тохижуулах анонс	28.8 м ²	13 000	374 400
2	DVD-ний ном хэвлэх цаас	2 боодол	12 500	25 000
3	DVD	500 ш	1 000	500 000
4	DVD-ний хуулга	5 боодол	14 000	70 000
5	DVD уут	5 боодол	500	2 500
6	Өнгөт хор	2 багц	20 000	40 000
	дүн			1 024 400

ҮЙЛ АЖИЛЛАГААГААРАА ТЭРГҮҮЛСЭН БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН ХАМТЫН МЕНЕЖМЕНТИЙН НӨХӨРЛӨЛҮҮДИЙН
УРАМШУУЛЛЫН ТӨСӨВ

д/д	Үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ/төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Тэргүүний нөхөрлөлийн урамшуулал	2	500 000	1000 000
	дүн			1000 000
	НИЙТ			2 024 400